



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 218

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн сахилгын хорооны ажлын албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 8 нэрийн, нийт 1,694,191.82 (нэг сая зургаан зуун ерэн дөрвөн мянга нэг зуун ерэн нэгэн төгрөг наян хоёр мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,042,772.40 (нэг сая дөчин хоёр мянга долоон зуун далан хоёр төгрөг дөчин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шүүх шинжилгээний ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Шүүхийн сахилгын хорооны Ажлын албаны дарга Д.Мөнхзориг, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга Ж.Буянбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001358
13-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 2 дүгээр сарын 29-ны өдрийн
218 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАРТ
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Бичгийн ширээ шаргал	2022-07-05	ш	3.00	61,734.17	185,202.51	138,901.86	46,300.65
2	Сандап 067	2022-07-05	ш	8.00	16,012.50	128,100.00	48,037.50	80,062.50
3	Шүүгээ бичиг хэргийн төмөр	2022-07-05	ш	1.00	319,704.86	319,704.86	59,944.68	259,760.18
4	Бичгийн ширээ даргын	2022-07-05	ш	2.00	59,565.04	119,130.08	89,347.50	29,782.58
5	Хурлын ширээ	2022-07-05	ш	1.00	168,670.93	168,670.93	126,503.28	42,167.65
6	Хурлын ширээ	2022-07-05	ш	1.00	225,000.11	225,000.11	168,750.00	56,250.11
7	Хурлын ширээ дугуй	2022-07-05	ш	1.00	467,083.67	467,083.67	350,312.76	116,770.91
8	Сэтгүүлийн ширээ даргын	2022-07-05	ш	1.00	81,299.66	81,299.66	60,974.82	20,324.84
Нийт дүн						1,694,191.82	1,042,772.40	651,419.42
						(нэг сая зургаан зуун ерэн дөрвөн мянга нэг зуун ерэн нэгэн төгрөг наян хоёр мөнгө)	(нэг сая дөчин хоёр мянга долоон зуун далан хоёр төгрөг дөчин мөнгө)	(зургаан зуун тавин нэгэн мянга дөрвөн зуун арван есөн төгрөг дөчин хоёр мөнгө)